

БАТЛАВ



БиДиСЕК УЦК ХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 19-ны
өдрийн 23/02 тоот тогтоолын Хавсралт №1

Д.ДАЯНБИЛГҮҮН
ТУЗ-ИЙН ДАРГА

“БИДИСЕК УЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 БиДиСЕК УЦК ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-тэй холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. Төлөөлөн удирдах зөвлөл

- 2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байна.
- 2.2 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн тоо нь компанийн дүрэмд зааснаар 9 гишүүнтэй байна. Компанийн тухай хуулийн 75.4-д зааснаар ТУЗ-ийн гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.
- 2.3 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн нь компанийн хувьцаа эзэмшигч биш байж болно.

ГУРАВ. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

- 3.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.1.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
 - 3.1.2 хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 3.1.3 хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг нэрсийн жагсаалтыг гаргах, бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 3.1.4 компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 3.1.5 компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
 - 3.1.6 эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 3.1.7 өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 3.1.8 компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

- 3.1.9 компанийн гүйцэтгэх удирдагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - 3.1.10 аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцлийг тогтоох;
 - 3.1.11 компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 3.1.12 ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;
 - 3.1.13 төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 3.1.14 компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
 - 3.1.15 компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 3.1.16 компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 3.1.17 компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 3.1.18 компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.
- 3.2 Дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө. /Хараат бус гишүүн гэж компанийн тухай хуулийн 79.1-т заасан этгээдийг хэлнэ/
- 3.2.1 Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 3.2.2 Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 3.2.3 Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.
- 3.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжилнэ.
- 3.4 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох эрхтэй.

Дөрөв. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно.
- 4.2. Төлөөлөн удирдах гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болгох ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.
- 4.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 4.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хувь хүн байна.
- 4.5. Компанийн тухай хуулийн 77.4-д заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнийг санал хураах кумулятив аргаар сонгох бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны журмыг дагаж мөрдөнө.

- 4.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрмөсөн буюу удаан хугацаагаар гишүүний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд төлөөлөх гишүүнийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл түр томилж болно.

Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

- 5.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
- 5.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хурал хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.
- 5.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.
- 5.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь компанийн Гүйцэтгэх захирал байж болохгүй.

Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

- 6.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүнийг дэвшүүлнэ.
- 6.1.1 өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй.
- 6.1.2 өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компани болон компанийн оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй.
- 6.1.3 төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй.
- 6.1.4 тухайн компанитай бизнестэй ямар нэгэн холбоогүй.
- 6.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний нэгэн адил эрх, үүрэгтэй байхаас гадна нэмэлт үүргийг хүлээнэ.
- 6.2.1 төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд шаардлага тавих, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх
- 6.2.2 компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах
- 6.2.3 хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

Долоо. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

- 7.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна, шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.
- 7.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлага болон компанийн дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга шаардлагаар хуралдуулна.
- 7.4 Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 7.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 7.6 Тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос хоёр дахин бага болсон тохиолдолд компани нь гурван сарын дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж болно.
- 7.8 Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.
- 7.9 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараахь зүйлсийг тусгана:
 - 7.2.1 хурал хийсэн газар болон өдөр, цаг
 - 7.2.2 хуралд оролцсон гишүүд
 - 7.2.3 хурлаар хэлэлцсэн асуудал
 - 7.2.4 санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн
 - 7.2.5 хурлаар гаргасан шийдвэр
- 7.10 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурах ба тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.
- 7.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргана.
- 7.12 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

Найм. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо

- 8.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.
- 8.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах хороодын байгуулна. Үүнд:
 - 8.2.1 Аудитын хороо
 - 8.2.2 Цалин, урамшууллын хороо

8.2.3 Нэр дэвшүүлэх хороо

8.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

8.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэд хороодын үйл ажиллагааг дотоод журмын дагуу зохицуулна.

Ес. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үүрэг, хариуцлага

9.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ.

9.1.1 Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэх, ойролцоо нөхцөл байдалд анхааралтай, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах;

9.1.2 Зарлагдсан хурлуудад оролцох, сонгогдсон ТУЗ-ийн хороодынхоо ажилд оролцох;

9.1.3 ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй шалтгаанаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэнэ;

9.2 Дараах ашиг, сонирхлын зөрчилдөөний дүрэм, журмын дагуу ажиллана. Үүнд:

9.2.1 Гишүүнээр ажиллаж буй компани болон түүний салбар компанийн үнэт цаастай холбоотой үйл ажиллагаанд оролцох зорилго гэх мэт компанийн үйл ажиллагаа, гэрээ, төсөлд хувийн арилжаа, ашиг сонирхлын улмаас (шууд болон шууд бус) оролцох бол энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэх ба үнэт цаастай холбоотой үйл ажиллагааныхаа талаар мэдээлнэ;

9.2.2 ТУЗ-ийн гишүүнээр ажиллах үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон компаниас халагдсаны дараа нэг (1) жилийн турш дээрх мэдээллийг ашиглах ёсгүй хүмүүст задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

9.2.3 Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах дотоод журмаар тогтоосон дүрэм, журмын дагуу ажиллах;

9.2.4 Хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв нөхцөл байдал байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр ажлын 10 хоногийн дотор мэдэгдэнэ.

Арав. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

10.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно.

10.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ.

9.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх

9.2.2. Хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл

болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх хүргэх ажлыг зохион байгуулах

- 9.2.3. Хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэнд хяналт тавих
- 9.2.4. Хувьцаа эзэмшигчдийн болон төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах
- 9.2.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан ажиллах
- 9.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.